

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/084/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Ч.Болд  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [boldch@audit.gov.mn](mailto:boldch@audit.gov.mn)

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр  
Утас: 11-315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер: Я.Алтанцэцэг  
Утас: 11-325093 Цахим хаяг: [altantsetsegya@audit.gov.mn](mailto:altantsetsegya@audit.gov.mn)

Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох  
Утас: 99063227 Цахим хаяг: [munkhtogtokh.e@solidunity.mn](mailto:munkhtogtokh.e@solidunity.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/304

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын газрын хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу хүнсний зориулалтай агуулахын барилгыг өмчийн дансанд бүртгэсэн байна. Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2024 оны А/238 тоот захирамжаар 247362 м<sup>2</sup> үр тарианы зориулалтаар эзэмшүүлсэн газрыг 2 жилээс дээш хугацаанд ашиглаагүй тул газар эзэмших эрхийг цуцалсан байна.

### Аудитын гол асуудал

Боловсролын ерөнхий газар болон Нийслэлийн боловсролын газраас цэцэрлэг, сургуулиудыг хүнсний бүтээгдэхүүнээ цахим дэлгүүрээс худалдан авах шаардлагыг 2024 онд хүргүүлсэн хэдий ч тайланд онд Сонгинохайрхан дүүргийн сургууль, цэцэрлэгүүд худалдан авалтаа тус байгууллагаас хийснээр борлуулалтын орлого буураагүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.7 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Тус байгууллагын үнэ тогтоох комисс хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч байгууллагуудын ирүүлсэн үнийн саналыг тухай бүрд судалж, тухайн бүтээгдэхүүний зах зээлд борлуулагдаж байгаа зах зээлийн үнийн судалгааг 3-4 газрын жишиг үнийг авч харьцуулан, худалдан борлуулах үнийг дунджаар 10-30 хувиар нэмж тогтоосон байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

# 1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	114,116,679.27	88,306,828.74
1.1.2	Дансны авлага	12,419,135.09	57,791,258.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	73,542.20
1.1.4	Бусад авлага	3,562,824.19	5,662,969.18
1.1.6	Бараа материал	58,381,442.45	81,552,523.53
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	164,130.00	1,289,773.09
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>188,644,211.00</b>	<b>234,676,894.74</b>
<b>1.2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	355,004,221.71	413,921,728.11
1.2.2	Биет бус хөрөнгө	34,675,460.00	14,675,460.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>389,679,681.71</b>	<b>428,597,188.11</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>578,323,892.71</b>	<b>663,274,082.85</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	80,000.00	-
2.1.1.3	Татварын өр	79,552,352.68	95,823,252.20
2.1.1.4	НДШ-ийн өглөг	609,167.97	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,571,726.12	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	530,652.44	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>87,343,899.21</b>	<b>95,823,252.20</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр төлбөр	1,645,007.84	292,491.54
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	246,439,729.76	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>248,084,737.60</b>	<b>292,491.54</b>
<b>2.2</b>	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>335,428,636.81</b>	<b>96,115,743.74</b>
<b>2.3</b>	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.3.1	Өмч-Төрийн	167,629,728.30	430,498,773.30
2.3.6	Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	14,793,440.50	14,793,440.50
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	14,675,460.00	14,675,460.00
<b>2.3.9</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>45,796,627.10</b>	<b>107,190,665.31</b>
2.3.9.1	Тайлант үеийн ашиг (алдагдал)	250,787,929.37	150,858,191.59
2.3.9.2	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг (алдагдал)	(204,991,302.27)	(43,667,526.28)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>242,895,255.90</b>	<b>567,158,339.11</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>578,323,892.71</b>	<b>663,274,082.85</b>

## 1.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>6,684,582,316.57</b>	<b>7,911,118,253.76</b>
2	Борлуулалтын өртөг	(5,820,729,571.61)	(6,900,231,403.55)
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>863,852,744.96</b>	<b>1,010,886,850.21</b>
4	Хүүний орлого	709,142.19	630,839.91
5	Бусад орлого	12,564,453.35	827,272.72
6	Борлуулалт маркетингийн зардал	(262,680,298.51)	(337,640,095.62)
7	Ерөнхий ба удирдлагын зардал	(329,856,290.22)	(476,449,340.49)
8	Бусад зардал	(5,124,890.36)	(11,117,683.27)
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	54,545.46	(20,000,000.00)
<b>10</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>279,519,406.87</b>	<b>167,137,843.46</b>
11	Орлогын татварын зардал	(28,731,477.50)	(16,279,651.87)
<b>12</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>250,787,929.37</b>	<b>150,858,191.59</b>
<b>13</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>250,787,929.37</b>	<b>150,858,191.59</b>

### 1.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
1	<b>2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>167,629,728.30</b>	<b>14,675,460.00</b>	-	<b>(158,137,289.53)</b>	<b>24,167,898.77</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	3,356,777.26	3,356,777.26
3	Зарласан ногдол ашиг	-	-	-	(50,210,790.00)	(50,210,790.00)
4	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	14,793,440.50	-	14,793,440.50
5	Тайлант үеийн үр дүн	-	-	-	250,787,929.37	250,787,929.37
6	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>167,629,728.30</b>	<b>14,675,460.00</b>	<b>14,793,440.50</b>	<b>45,796,627.10</b>	<b>242,895,255.90</b>
7	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>167,629,728.30</b>	<b>14,675,460.00</b>	<b>14,793,440.50</b>	<b>45,796,627.10</b>	<b>242,895,255.90</b>
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(14,227,753.38)	(14,227,753.38)
9	Зарласан ногдол ашиг	-	-	-	(75,236,400.00)	(75,236,400.00)
10	Өмчид гаргасан өөрчлөлт	262,869,045.00	-	-	-	262,869,045.00
11	Тайлант үеийн үр дүн	-	-	-	150,858,191.59	150,858,191.59
12	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>430,498,773.30</b>	<b>14,675,460.00</b>	<b>14,793,440.50</b>	<b>107,190,665.31</b>	<b>567,158,339.11</b>

## 1.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>7,351,099,170.99</b>	<b>8,658,688,495.54</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,341,873,848.00	8,654,596,911.00
1.1.2	Бусад мөнгөн орлого	9,225,322.99	4,091,584.54
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>7,262,181,099.48</b>	<b>8,514,005,586.07</b>
1.2.1	Ажиллагсад төлсөн мөнгө	325,414,392.03	449,320,072.05
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	97,684,567.52	130,280,385.52
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	6,056,647,987.22	7,229,201,555.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	63,854,734.26	91,371,539.21
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	23,901,250.00	24,758,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн мөнгө	671,266,167.80	533,404,303.68
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	218,840.00	540,270.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	23,193,160.65	55,129,460.61
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>88,918,071.51</b>	<b>144,682,909.47</b>
<b>2</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
2.1.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	102,780,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>102,780,000.00</b>
<b>3</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>45,189,710.00</b>	<b>67,712,760.00</b>
3.1.1	Төлсөн ногдол ашиг	45,189,710.00	67,712,760.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(45,189,710.00)</b>	<b>(170,492,760.00)</b>
<b>4</b>	<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>43,728,361.51</b>	<b>(25,809,850.53)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>70,388,317.76</b>	<b>114,116,679.27</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>114,116,679.27</b>	<b>88,306,828.74</b>

## 1.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2023 он	2024 он		Зөрүү	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	6,684,582.3	7,873,128.0	7,911,118.3	(37,990.3)	100.5
2	Үйл ажиллагааны бусад орлого	13,328.1	8,371.7	1,458.2	6,913.6	17.4
<b>Нийт орлого</b>		<b>6,697,910.5</b>	<b>7,881,499.7</b>	<b>7,912,576.4</b>	<b>(31,076.7)</b>	<b>100.4</b>
3	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>5,820,729.6</b>	<b>6,920,479.5</b>	<b>6,900,231.4</b>	<b>20,248.1</b>	<b>99.7</b>
4	Цалин	399,786.2	628,795.5	542,069.1	86,726.4	86.2
5	НДШ	49,919.0	78,599.4	66,719.7	11,879.7	84.9
6	Шуудан холбоо	4,312.1	5,760.0	3,506.8	2,253.2	60.9
7	Цахилгааны зардал	5,025.8	9,468.3	7,962.6	1,505.7	84.1
8	Шатахууны зардал	17,088.2	22,110.1	16,809.8	5,300.2	76.0
9	Албан томилолт	-	8,000.0	-	8,000.0	0.0
10	Бичиг хэргийн зардал	3,274.1	5,848.0	4,456.4	1,391.6	76.2
11	Хог хаягдлын зардал	840.0	480.0	480.0	-	100.0
12	Сэлбэг хэрэгслийн зардал	12,532.2	7,200.0	3,785.5	3,414.5	52.6
13	Хангамжийн материалын зардал	7,584.7	-	-	-	0.0
14	Хөдөлмөр хамгааллын хувцас	-	5,580.0	5,561.7	18.3	99.7
15	Ашиглалтын зардал	2,188.8	7,569.0	6,933.0	636.0	91.6
16	Түрээсийн зардал	45,380.0	64,200.0	62,590.0	1,610.0	97.5
17	Засвар үйлчилгээ	798.5	3,500.0	20,889.6	(17,389.6)	596.8
18	Бусад зардал	10,633.5	12,900.0	10,314.4	2,585.6	80.0
19	Шагнал урамшуулал	-	9,000.0	10,443.4	(1,443.4)	116.0
20	Элэгдлийн зардал	30,539.5	32,825.0	41,360.0	(8,535.0)	126.0
21	Сургалтын зардал	2,634.2	10,000.0	2,168.0	7,832.0	21.7
22		-	-	8,039.5	(8,039.5)	100.0
<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>592,536.80</b>	<b>911,835.3</b>	<b>814,089.5</b>	<b>97,745.8</b>	<b>89.3</b>
23	Үйл ажиллагааны бус зардал	5,124.9	17,300.0	11,117.7	6,182.3	64.3
24	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	-	20,000.0	(20,000.0)	(100.0)
<b>Нийт зардлын дүн</b>		<b>6,418,391.30</b>	<b>7,849,614.8</b>	<b>7,745,438.6</b>	<b>104,176.2</b>	<b>98.7</b>
25	Татвар төлөхийн өмнөх ашиг	279,519.4	31,884.9	167,137.8	(135,252.9)	524.2
26	Татварын зардал	28,731.5	4,918.5	16,279.7	(11,361.2)	331.0
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>		<b>250,787.9</b>	<b>26,966.4</b>	<b>150,858.2</b>	<b>(123,891.8)</b>	<b>559.4</b>
27	Орлогын нэг төгрөгт ногдох зардал	0.96	0.99	0.98	-	97.9

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

2.1 Аудитаар нийт 289,074.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Оффисын байрны түрээсийн барьцаа төлбөр 3,853.7 мянган төгрөгийг дансны авлагаар толилуулсан;
- Шатахууны картын урьдчилгаа төлбөр 945.9 мянган төгрөгийг дансны авлагаар толилуулсан;
- Тайлант хугацаанд ААНОАТ-ын өр төлбөрийн үлдэгдэл төлбөрийг 1,431.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Автомашины дулаан зогсоолын төлбөр 6,100.0 мянган төгрөгийг цэвэрлэгээний зардал дансанд бүртгэсэн;
- 2023 оны гражийн төлбөр 3,300.0 мянган төгрөгийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 250,787.9 мянган төгрөгийг тайлант үеийн ашгаар толилуулсан;
- Үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн зорилгоор элэгдүүлэх хугацаа болон татварын зорилгоор элэгдүүлэх хугацааны түр зөрүүнээс үүсэх хойшлогдсон татварыг 2,175.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцоолж бүртгэлд тусгасан;
- Автомашины засварын зардал болох 6,377.7 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөд капиталжуулж бүртгээгүй;
- Тайлант онд 557.6 мянган төгрөгөөр худалдан авсан ус шүүгчийг бусад үндсэн хөрөнгөөр бүртгээгүй;
- Мөнгөн гүйлгээний тайланд компьютер техник хэрэгсэл худалдаж авахад төлсөн 12,880.0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хэсэгт толилуулаагүй;
- ААНОАТ-ын зардлыг 664.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.

Аудитаар нийт 16,736.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 16,736.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 50,241.8 мянган төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **2.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. ААНОАТ-аас хасагдахгүй зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант хугацаанд засвартай байсан автомашины элэгдлийн зардал 1,600.0 мянган төгрөг, автомашины засварын зардалд бүртгэсэн тухайн хөрөнгийн үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтэрсэн 2,778.9 мянган төгрөг, мөн дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгүүдийн элэгдлийн зардал 7,212.4 мянган төгрөгийн зардлуудыг ААНОАТ-д хасагдах зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.2-т "Албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх", 13.2.8-д "Урсгал засварын зардал нь сэлбэг хэрэгслийн зардлыг багтаасан байх бөгөөд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхгүй бөгөөд үүнээс хэтэрсэн урсгал засварын зардлыг их засварын зардалд тооцох", 17.2-т "Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл хэсгийн дүнд элэгдэл, хорогдол тооцохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид татвар ногдох орлоготой холбогдон гарсан зардлуудыг хасагдах зардлаар тооцоолж, татварын тайланг үнэн зөв тайлагнаж байх.

### **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байгууллагын үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа 4 нэр төрлийн 14 ширхэг хөрөнгийг дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 онд баталсан "Журам шинэчлэх тухай" 271 дүгээр тогтоолын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засан сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр тайлагнах, ашиглахгүй хөрөнгүүдийг актлах саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Оффисын байрны түрээсийн барьцаа төлбөр 3,853.7 мянган төгрөгийг дансны бусад авлагаар толилуулаагүй байна.	1	3,853.7					1	3,853.7				
Шатахууны картын төлбөр 945.9 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардал тооцоо дансанд толилуулаагүй байна.	1	945.9					1	945.9				
Өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг тайлант үеийн ашгаар илэрхийлсэн байна.	1	250,787.9					1	250,787.9				
Автомашин дулаан зогсоолын төлбөр 6,100.0 мянган төгрөгийг цэвэрлэгээний зардалд ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.	1	6,100.0					1	6,100.0				
Автомашин засварын зардал болох 6,377.7 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөд капиталжуулж бүртгээгүй байна.	1	6,377.7					1	6,377.7				
Тайлант онд 557.6 мянган төгрөгөөр худалдан авсан ус шүүгчийг бусад үндсэн хөрөнгөөр бүртгээгүй байна.	1	557.6					1	557.6				
Үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн зорилгоор элэгдүүлэх хугацаа болон татварын зорилгоор элэгдүүлэх хугацааны түр зөрүүнээс үүсэх хойшлогдсон татварыг алдаатай бүртгэсэн байна.	1	2,175.0					1	2,175.0				
ААНОАТ-ын өглөгийн үлдэгдлийг 1,431.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.	1	1,431.5					1	1,431.5				
2023 оны 11 болон 12-р сарын гражын түрээсийн төлбөрийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	3,300.0					1	3,300.0				
Мөнгөн гүйлгээний тайланд компьютер техник хэрэгсэл худалдаж авахад төлсөн 12,880.0 мянган	1	12,880.0					1	12,880.0				

төгрөгийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хэсэгт толилуулаагүй байна.												
ААНОАТ-ын зардлыг зөрүүтэй бүртгэсэн.	1	664.9					1	664.9				
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>289,074.2</b>					<b>11</b>	<b>289,074.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд засвартай байсан автомашины элэгдлийн зардал 1,600.0 мянган төгрөг, автомашины засварын зардалд бүртгэсэн тухайн хөрөнгийн үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтэрсэн 2,778.9 мянган төгрөг, мөн дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгүүдийн элэгдлийн зардал 7,212.4 мянган төгрөгийн зардлуудыг ААНОАТ-д хасагдах зардлаар тайлагнасан байна.	1	11,591.3					1	11,591.3				
Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 4 нэр төрлийн 14 ширхэг 5,145.5 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгээгүй байна.	1	5,145.5					1	5,145.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>16,736.8</b>					<b>2</b>	<b>16,736.8</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 69,378.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ, зарлагын 5,668.9 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, Мөн орлогын 1,006,142.7 мянган төгрөгийн 86 гүйлгээ, зарлагын 2,040,801.5 мянган төгрөгийн 52 гүйлгээ тус тус хугацаа хоцроон мэдээлсэн байна.	1	3,121,991.1	1	3,121,991.1		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,121,991.1</b>	<b>1</b>	<b>3,121,991.1</b>		